

О.Жамьян гүнгийн найруулсан хэл зүйн бичгүүд



СОЁЛЫН ЯАМ

**О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН
ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД**

VI

УЛААНБААТАР ХОТ

2023

О.Жамьян гүнгийн найруулсан хэл зүйн бичгүүд



СОЁЛЫН ЯАМ

“МОНГОЛ ҮСГИЙН ЦАГААН ТОЛГОЙ ОРШИВ”

МОНГОЛ БИЧГЭЭС ГАЛИГЛАЖ, ХӨРВҮҮЛСЭН: П.ТӨРБОЛД

ХЯНАСАН: Б.СУВД

ISBN: 978-9919-0-1782-8

“МОНГОЛ ҮСГИЙН ЦАГААН ТОЛГОЙ ОРШИВ”

О.Жамьян гүний туурвисан энэхүү зохиол нь нийт гарчиг нүүрийн хамт 20 нүүр, таваас зургаан мөрөөр бичсэн, бийрийн бичмэл эх. 1926 онд Ардыг гэгээрүүлэх яамнаас эрхлэн хэвлүүлжээ.

Зохиолын агуулга: Тус зохиол нь “монголын цагаан толгойн нэг зуун үсэг” гэдэг нь алин болохыг тоочиж, түүний дээр “хойно нэмсэн уг үсгийн дотроос олонтаа хэрэглэдэг хэдэн үсэг”-ийг нэмж бичсэнээр эхэлнэ.

Үүний дараа цагаан толгойн үсгүүдийг эр хэмээх чанга, эм хэмээх хөндий, эрс хэмээх саармагаар нь ялгахыг үзүүлж, эгшгээр амилуулсан хэлбэрийг ч мөн тоочжээ. Ингээд эр, эм, эрс үсгийг хэрхэн хэрэглэхийг зааж, бас монголын нэг зуун гучин таван үсгийн үгийн дунд амьтай орох байдлыг тодорхойлон, -на-, -нэ-, -но-, -ну-, -нө-, -нү- гэхчлэн долоон эгшгээр амилуулсан хэлбэрийг жагсаажээ. Мөн эдгээр олон үсгийг үгийн адагт амьтайгаар орох байдлыг ч үзүүлсэн байна.

Зохиогч а-ийн төрлийн долоон үсгийг тодорхойлохдоо: “*бичгийн тэргүүнд явахаас бус, үсгийн дунд ба адагт бичиж үл болмуй. Учир юун хэмээвээс үсэг бүр а-гийн эгшигтэйгээр дуудагдах тул, эгшиг үсэг хэмээмүй. а-гийн эгшиг бүхүй үсгийг амьтай үсэг*” хэмээн бичив. Мөн түүнчлэн амьтай үсгийн эсрэг амьгүй үсэг гэдгийн учир болон амьгүй үсгийг юуны учир “дэвсгэр үсэг” гэдэг болохыг товч дурдаад, дэвсгэр үсгийг дагаж ордог тэр арван үсэг нь “*на, га, да, ма, ла, ба, йа, са, ва хийгээд инхлэг лүгээ арван нэг¹ болой*” гэжээ. Инхлэг үсгийг тодорхойлохдоо “*зуун үсэгт оролцсонгүй -нг хэмээх нэгэн үсэг буй*” гээд түүнийг дэвсгэрт оруулжээ. Эдгээр арван нэгэн дэвсгэр үсгийг үгийн дунд амьтай, амьгүй бичих тухай болон үгийн дунд, адагт орох байдлыг ч тоочин үзүүлэв.


Тэгвэл “нөхцөл”-ийг “*дагах үсэг ч хэмээдэг буй*” гээд, хэрхэн дагуулахыг ч харуулжээ.

Дараа нь эгшиг үсгийг “*а-гийн эгшиг бүхий амьтай үсэг мөн болой*” хэмээсэн бол “*а-гийн эгшигийг хассан дэвсгэр хэмээх амьгүй үсэг*”-ийг дагах ёсыг мөн үзүүлэв. Ингээд эр үсгийг дагах ёс, эм ба саармаг үсгийг дагах ёс, бас йа дэвсгэрийн доор на, га, да, ма, ла, ра, са долоон үсгийг дэвсэж давхар дэвсгэр хэмээдэг болохыг ч товч бөгөөд тодорхой үзүүлсэн байна.

Төгсгөлийн үг: “*Үүний дотор үзүүлсэн нь үсгийн байдлыг гүйцэтгэн чадсангүй боловч сая сурах хүүхдэд үлгэрлэн ухуулбаас асар дутагдахгүй болж болох болов уу хэмээмүй хэмээсэн үүнийг Монгол улсын арван зургаадугаар он цагаан сар бөгөөд европын нэгэн мянга есөн зуун хорин зургаадугаар он гурван сарын сайн өдөр Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн дарга Жамьян хэмээгдэх бээр бичив. Үүгээр сурах хүүхдийн оюуны ам нээгдэх болтугай*” гэжээ.


Зохиогч төгсгөлийн үгэндээ уг зохиолыг хэдэн онд, хаана зохиосноо монгол улсын болон европын цаг тооллын дагуу маш тодорхой бичсэнээс гадна өөрийн эрхэлсэн алба, нэрийг бичиж, зохиолоо хэнд зориулснаа товч бөгөөд тодорхой бичиж төгсгөсөн байна.

¹ Ра үсэг дутуу.



mongyol üsüg-ün čayan toluyai orosibai.

МОНГОЛ ҮСГИЙН ЦАГААН ТОЛГОЙ ОРШИВ




ГАЛИГ

- 01.01 a e i o u ö ü, na ne ni no nu nö nü,
- 01.02 γa ge gi γo γu gö gü, qa ke ki qo qu kö kü,
- 01.03 da de di do du dö dü, ta te ti to tu tö tü,
- 01.04 ma me mi mo mu mö mü, la le li lo lu lö lü,
- 01.05 ba be bi bo bu bö bü, ra re ri ro ru rö rü
- 01.06 ja je ji jo ju jö jü, ča če či čo ču čö čü,

ХӨРВҮҮЛЭГ

а э и о у ө ү; на нэ ни но ну нө нү; га гэ ги го гу гө гү; ха хэ хи хо ху хө хү; да дэ ди до ду дө дү; та тэ ти то ту тө тү; ма мэ ми мо му мө мү; ла лэ ли ло лу лө лү; ба бэ би бо бу бө бү; ра рэ ри ро ру рө рү; жа жэ жи жо жу жө жү; ча чэ чи чо чу чө чү;



ГАЛИГ

02.01 egüni mongyol-un čayan toluyai-yin jayun üsüg kememüi.

02.02 qoyin-a nemegsen uy üsüg-ün doturača olanta keregledeg kedün


02.03 üsüg-i nemen bičibesü eyin buyu.

02.04 pa pe pi po pu pö pü, za ze zi zo zu zö zü,

02.05 ca ce ci co cu cö cü, ša še ši šo šu šö šü,

ХӨРВҮҮЛЭГ

Үүнийг монголын цагаан толгойн нэг зуун үсэг хэмээмүй. Хойно нэмсэн уг үсгийн дотроос олонтаа хэрэглэдэг хэдэн үсгийг нэмэн бичвээс ийн буюу. па пэ пи по пу пө пү; за зэ зи зо зу зө зү; ца цэ ци цо цу цө цү; ша шэ ши шо шу шө шү;



ГАЛИГ

03.01 lha lhe lhi lho lhu lhö lhü,

03.02 mongγol-un čayan toluyai-yin bügüde üsüg-ün dotur-a er-e kemekü

03.03 čingγ-a, em-e kemekü köndei, ersü kemekü sayarmay ilγal bui.


03.04 ali bui kemebesü,

03.05 a o u, na no nu, γa γo γu, qa qo qu, da do du,

03.06 ta to tu, ma mo mu, la lo lu, ba bo bu, ra ro ru,

ХӨРВҮҮЛЭГ

лха лхэ лхи лхо лху лхө лхү. Монголын цагаан толгойн бүгд үсгийн дотор эр хэмээх чанга, эм хэмээх хөндий, эрс хэмээх саармаг ялгал буй. Аль буй хэмээвээс, а о у; на но ну; га го гу; ха, хо, ху; да до ду; та то ту; та то ту; ма мо му; ла ло лу; ба бо бу; ра ро ру;



ГАЛИГ

04.01 čöm er-e üsüg bolai.

04.02 e ö ü, ne nö nü, ge gö gü, ke kö kü, de dö dü,


04.03 te tö tü, me mö mü, le lö lü, be bö bü,

04.04 re rö rü, je jö jü, ce čö č, ye yö yü,

04.05 se sö sü, we, ene inu čöm em-e üsüg bolai.

ХӨРВҮҮЛЭГ

Цөм эр үсэг болой. э ө ү; нэ нө нү; гэ гө гү; хэ хө хү; дэ дө дү; тэ тө тү; мэ мө мү; лэ лө лү; бэ бө бү; рэ рө рү; жэ жө жү; чэ чө чү; йэ йө йү; сэ сө сү; вэ. Энэ нь цөм эм үсэг болой.



ГАЛИГ

05.01 i ni gi ki di ti mi li bi ri ji čī yi si, ene inu

05.02 čöm saγarmaγ üsüg bolai.

05.03 er-e em-e qoyar nigen ügen-dür qabsurun bičijü ülü

05.04 bolumui. saγarmaγ üsüg bolbasu er-e ba em-e üsüg-ün alin-dur


05.05 bolbaču qabsurun bičijü bolumui. basa deger-e nemen bičigsen-ü

05.06 zi ci ši lhi terigüten γučin tabun üsüg mөн jaγun üsüg-ün

ХӨРВҮҮЛЭГ

и ни хи ги ди ти ми ли би ри жи чи йи си энэ нь цөм саармаг үсэг болой.

Эр, эм хоёр үсгийг нэг үгэнд хавсран бичиж үл болмуй. Саармаг үсэг болбоос эр ба эм үсгийн алинд боловч хавсран бичиж болмуй. Бас дээр нэмэн бичсэний за ца ша лха тэргүүтэн гучин таван үсэг мөн зуун үсгийн




ГАЛИГ

- 06.01 adali γurban er-e γurban em-e, nigen sayarmay bolqu-yi medegdeküi.
06.02 egünče degeḡši mongyol-un nigen jayun γučin tabun üsüg-i
06.03 aliba üsüg-ün dumda ami-tai oruqu bayidal-i todurqayilabasu eyin buyu.
06.04 -na- -ne- -ni- -no- -nu- -nö- -nü-; -γa- -ge- -gi- -γo- -γu- -gö- -gü-;
06.05 -qa- -ke- -ki- -qo- -qu- -kö- -kü-, -da- -de- -di- -do- -du- -dö- -dü-,
06.07 -ta- -te- -ti- -to- -tu- -tö- -tü-, -ma- -me- -mi- -mo- -mu- -mö- -mü,

ХӨРВҮҮЛЭГ

адил гурван эр, гурван эм, нэг саармаг болохыг мэдтүгэй. Үүнээс дээш монголын нэг зуун гучин таван үсгийг аливаа үсгийн дунд амьтай орох байдлыг тодорхойлбоос ийн буюу. -на- -нэ- -но- -ну- -нө- -нү-; -га- -гэ- -ги- -го- -гу- -гө- -гү-; -ха- -хэ- -хи- -хо- -ху- -хө- -хү-; -да- -дэ- -ди- -до- -ду- -дө- -дү-; -та- -тэ- -ти- -то- -тө- -тү-; -ма- -мэ- -ми- -мо- -му- -мө- -мү-;



ГАЛИГ

07.01 -la- -le- -li- -lo- -lu- -lö- -lü, -ba- -be- -bi- -bo- -bu- -bö- -bü-,

07.02 -ra- -re- -ri- -ro- -ru- -rö- -rü-, -ja- -je- -ji- -jo- -ju- -jö- -jü-,

07.03 -ča- -če- -či- -čo- -ču- -čö- -čü-, -ya- -ye- -yi- -yo- -yu- -yö- -yü-,


07.04 -sa- -se- -si- -so- -su- -sö- -sü-, -wa- -we-,

07.05 -pa- -pe- -pi- -po- -pu- -pö- -pü-, -za- -ze- -zi- -zo- -zu- -zö- -zü-,

07.06 -ca- -ce- -ci- -co- -cu- -cö- -cü-, -ša- -še- -ši- -šo- -šu- -šö- -šü-,

ХӨРВҮҮЛЭГ

-ла- -лэ- -ли- -ло- -лу- -лө- -лү; -ба- -бэ- -би- -бо- -бу- -бө- -бү; -ра- -рэ- -ри- -ро- -ру- -рө- -рү; -жа- -жэ- -жи- -жо- -жу- -жө- -жү; -ча- -чэ- -чи- -чо- -чу- -чө- -чү; -йа- -йэ- -йи- -йо- -йу- -йө- -йү; -са- -сэ- -си- -со- -су- -сө- -сү; -ва- -вэ; -па- -пэ- -пи- -по- -пу- -пө- -пү; -за- -зэ- -зи- -зо- -зу- -зө- -зү; -ца- -цэ- -ци- -цо- -цу- -цө- -цү; -ша- -шэ- -ши- -шо- -шу- -шө- -шү;



ГАЛИГ

08.01 -lha- -lhe- -lhi- -lho- -lhu- -lhö- -lhü-,

08.02 basa edeger olan üsüg-i aliba üsüg-ün aday-tur ami-tai-bar

08.03 oruqu bayidal-i todurqayilabasu eyin buyu.

08.04 -n-a -n-e -ni -no -nu -nö -nü; -γ-a -ge -gi -γo -γu -gö -gü;


08.05 -q-a -ke -ki -qo -qu -kö -kü; -da -de -di -do -du -dö -dү;

08.06 -ta -te -ti -to -tu -tö -tü; -ma -me -mi -mo -mu -mö -mү,

ХӨРВҮҮЛЭГ

-лха- -лхэ- -лхи- -лхо- -лху- -лхө- -лхү-.

Бас эдгээр олон үсгийг аливаа үсгийн адагт амьтайгаар орох байдлыг тодорхойлбоос ийн буюу. -н-а -н-э -ни -но -ну -нө -нү; -г-а -гэ -ги -го -гу -гө -гү; -х-а -хэ -хи -хо -ху -хө -хү; -да -дэ -ди -до -ду -дө -дү; -та -тэ -ти -то -ту -тө -тү;




ГАЛИГ

- 09.01 -la -le -li -lo -lu -lө -lү, -ba -be -bi -bo -bu -bö -bү,
- 09.02 -ra -re -ri -ro -ru -rө -rү, -ja -je -ji -jo -ju -jө -jү,
- 09.03 -ča -če -či -čo -ču -čө -чү, -y-a -y-e -yo -yu -yө -yү,
- 09.04 -sa -se -si -so -su -sө -sү, -w-a -w-e,
- 09.05 -pa -pe -pi -po -pu -pө -pү, -za -ze -zi -zo -zu -zө -zү,
- 09.06 -ca -ce -ci -co -cu -cө -cү, -ša -še -ši -šo -šu -šө -шү,

ХӨРВҮҮЛЭГ

-ла -лэ -ли -ло -лу -лө -лү; -ба -бэ -би -бо -бу -бө -бү; -ра -рэ -ри -ро -ру -рө -рү; -жа -жэ -жи -жо -жу -жө -жү; -ча -чэ -чи -чо -чу -чө -чү; -й-а -й-э -й-о -й-у -й-ө -й-ү; -са -сэ -си -со -су -сө -сү; -у-а -ү-э; -па -пэ -пи -по -пу -пө -пү; -за -зэ -зи -зо -зу -зө -зү; -ца -цэ -ци -цо -цу -цө -цү; -ша -шэ -ши -шо -шу -шө -шү;




ГАЛИГ

- 10.01 -lha -lhe -lhi -lho -lhu -lhö -lhü,
- 10.02 a-yin törül-yin doluyan üsüg bolbasu bičig-ün terigün-dür
- 10.03 yabuqu-ača busu üsüg-ün dumda ba aday-dur bičijü ülü bolumui.
- 10.04 učir yaγun kemebesü üsüg büri a-yin egesig-tei-ber
- 10.05 dayudaydaqu tula, egesig üsüg kememüi. a-yin egesig бүкүй
- 10.06 üsüg-i ami-tai üsüg kemen bičibei, a-yin egesig qasuγsan-i

ХӨРВҮҮЛЭГ

-лха -лхэ -лхи -лхо -лху -лхө -лхү; а-ийн төрлийн долоон үсэг болбоос, бичгийн тэргүүнд явахаас бус, үсгийн дунд ба адагт бичиж үл болмуй. Учир юун хэмээвээс үсэг бүр а-гийн эгшигтэйгээр дуудагдах тул, эгшиг үсэг хэмээмүй. а-гийн эгшиг бүхүй үсгийг амьтай үсэг хэмээн бичив. а-гийн эгшгийг хассаныг




ГАЛИГ

- 11.01 inu ami ügei üsüg kemen kelejü bolumui. yambar üsüg-yin
- 11.02 a-yin egesig-i qasuyad ami ügei üsüg kememüi kemebesü
- 11.03 aliba üsüg-üd-dür debisker bolju dayaqu arban üsüg-i ögülejüki.
- 11.04 tere arban üsüg ali bui kemebesü, na γa da ma la ba ya
- 11.05 sa wa kiged ingkelig-lüge arban nige bolai.
- 11.06 ingkelig kemegçi yambar üsüg-i ögülemüi kemebesü jayu

ХӨРВҮҮЛЭГ

нь амьгүй үсэг хэмээн хэлж болмуй. Ямар үсгийн а-гийн эгшгийг хасаад амьгүй үсэг хэмээмүй хэмээвээс, аливаа үсгүүдэд дэвсгэр болж дагах арван үсгийг өгүүлжээ. Тэр арван үсэг аль вэ хэмээвээс, на га да ма ла ба йа са ва хийгээд инхлэг лүгээ арван нэг болой. Инхлэг хэмээгч ямар үсгийг өгүүлмүй хэмээвээс зуун




ГАЛИГ

- 12.01 üsüg-dür orulčaysan ügei ng kemekü nigen üsüg bui tegün-ü
- 12.02 debisker-dür oruyuljuqui.
- 12.03 edeger arban nigen debisker üsüg-i dumda oruqu bayidal-i
- 12.04 üjegülküi-dür emünedü suyum-dur ami-tai-bar bičijü gereči bolyabai.
- 12.05 daray-a suyum-dur ami ügei-ber debisker bolju dumda oruqu
- 12.06 bayidal-i üjegülküi-dür eyin buyu. -na- -ya- -da- -ma- -la- -ba- -ra- -ya-

ХӨРВҮҮЛЭГ

үсэгт оролцсонгүй нг хэмээх нэгэн үсэг буй. Түүнийг дэвсгэрт оруулжээ. Эдгээр арван нэгэн дэвсгэр үсгийг дунд орох байдлыг үзүүлэхэд өмнөд шугамд амьтайгаар бичиж гэрч болгов. Дараа шугамд амьгүйгээр дэвсгэр болж дунд орох байдлыг үзүүлэхэд ийн буюу. -на- -га- -да- -ма- -ла- -ба- -ра- -йа-



ГАЛИГ

13.01 -sa- -wa- -ng-, n γ d m l b r y s w ng.

13.02 aday-tur oruqu bayidal anu, na γa da ma la ba ra ya

13.03 sa wa ha, n γ d m l b r y s ng, ene metü bolumui.


13.04 basa degedü üsüg-tür nökücel bolγaqu olan bui. tedeger-i

13.05 dayaqu üsüg čü kemedeg bui. ali üsüg mön yambar üsüg-dür

13.06 dayaqu yosun-i küsünüg-dür talbibasu eyin bui. -q-a-yi -yin -bar

ХӨРВҮҮЛЭГ

-са- -ва- -нг-, н г д м л м р й с у н г. Адагт орох байдал нь, на га да ма ла ба ра йа са ва нг, -н -г -д -м -л -б -р -й -с -у -нг энэ мэт болмуй. Бас дээд үсэгт нөхцөл болгох олон буй. Тэдгээрийг дагах үсэг ч хэмээдэг буй. Аль үсэг мөн ямар үсэгт дагах ёсыг хүснэгт тавиваас ийн буй. -н-а-ыг -ийн -бар




ГАЛИГ

- 14.01 -ban -dur -dayan , -γ-a-yi -yin -bar -ban -dur -dayan,
- 14.02 q-a-yi -yin -bar -ban -dur -dayan, -da-yi -yin -bar -ban -dur -dayan,
- 14.03 -ma-yi -yin -bar -ban -dur -dayan, -la-yi -yin -bar -ban -dur -dayan,
- 14.04 -ba-yi -yin -bar -ban -dur -dayan, -r-a-yi -yin -bar -ban -dur -dayan,
- 14.05 -ja-yi -yin -bar -ban -dur -dayan, -ča-yi -yin -bar -ban -dur -dayan,
- 14.06 -y-a-yi -yin -bar -ban -dur -dayan, -sa-yi -yin -bar -ban -dur -dayan,

ХӨРВҮҮЛЭГ

-бан -дур -даган ; г-а-ыг -ийн -бар -бан -дур -даган ; -да-г -ийн -бар -бан -дур -даган ; -ма-г -ийн -бар -бан -дур -даган ; -ла-г -ийн -бар -бан -дур -даган ; ба-г -ийн -бар -бан -дур -даган ; -р-а-ыг -ийн -бар -бан -дур -даган ; -жа-г -ийн -бар -бан -дур -даган ; -ча-г -ийн -бар -бан -дур -даган ; -й-а-ыг -ийн -бар -бан -дур -даган ; -са-г -ийн -бар -бан -дур -даган




ГАЛИГ

- 15.01 -w-a-yi -yin -bar -ban -dur -dayan,
- 15.02 ene inu kedüken tedüi-i bičigsen bolbaču, egesig üsüg-i dayaqu
- 15.03 üsüg ene bolai. egesig kemegči yambar üsüg-i ögülemüi kemebesü
- 15.04 a-yin egesig бүкүй ami-tai üsüg мөн bolai, a-yin egesig-i
- 15.05 qasuγsan debisker kemekü ami ügei üsüg-i dayaqu yosun-i
- 15.06 күсүнүг-дүр talbibasu eyin buyu. n-i -u -iyar -iyan -dur -dayan;

ХӨРВҮҮЛЭГ

-у-а-ыг -ийн -бар -бан -дур -даган ; Энэ нь хэдхэн төдийг бичсэн боловч эгшиг үсгийг дагах үсэг энэ болой. Эгшиг хэмээгч ямар үсгийг өгүүлмүй хэмээвээс а-гийн эгшиг бүхий амьтай үсэг мөн болой. а-гийн эгшгийг хассан дэвсгэр хэмээх амьгүй үсгийг дагах ёсыг хүснэгт тавиваас ийн буюу. -н-ийг -у -ийар -ийан -дур -даган




ГАЛИГ

- 16.01 n ng-i -un -iyar -iyan -tur -taγan -tegen;
- 16.02 -d-i -un -iyar -iyan -tur -taγan; -m-i -un -iyar -iyan -dur -dayan;
- 16.03 -l-i -un -iyar -iyan -dur -dayan; -b-i -un -iyar -iyan -tur -taγan;
- 16.04 -r-i -un -iyar -iyan -tur -taγan; y-yi -yin -bar -ban -dur -dayan;
- 16.05 -s-i -un -iyar -iyan -tur -taγan; -w-yi -yin -bar -ban -dur -dayan;
- 16.06 -ng-i -un -iyar -iyan -dur -dayan; edeger bolumui.

ХӨРВҮҮЛЭГ

-н -нг-ийг -ун -ийар -ийан -тур -таган; -д-ыг -ун -ийар -ийан -тур -таган; -м-ийг -ун -ийар -ийан -тур -таган; -л-ийг -у -ийар -ийан -тур -таган; -б-ыг -ун -ийар -ийан -тур -таган; -р-ыг -ун -ийар -ийан -тур -таган; -й-ийг -ийн -бар -бан -дур -даган ; -с-ийг -ун -ийар -ийан -тур -таган; -в-ыг -ийн -бар -бан -дур -даган ; -нг-ийг -ун -ийар -ийан -дур -даган ; эдгээр болмуй.




ГАЛИГ

- 17.01 er-e üsüg-i dayaqu yosun anu,
17.02 na anu -луҮ-а -нуҮүд - даҮҮан -таҮҮан; но anu -луҮ-а -нуҮүд -даҮҮан -таҮҮан;
17.03 nu anu -луҮ-а -нуҮүд - даҮҮан -таҮҮан; em-e ba sayarmay üsüg-i
17.04 dayaqu yosun anu ne inu -лүҮгэ -нүҮгүд -деҮҮген -теҮҮген;
17.05 nö inu -лүҮгэ -нүҮгүд -деҮҮген -теҮҮген; nü inu -лүҮгэ -нүҮгүд -деҮҮген -теҮҮген;
17.06 ni inu -лүҮгэ -нүҮгүд -деҮҮген -теҮҮген; basa ya debisker-ün door-a

ХӨРВҮҮЛЭГ

Эр үсгийг дагах ёс нь, -на ану -лугаа -нугууд -даган -таган; но ану -лугаа -нугууд -даган -таган; ну ану -лугаа -нугууд -даган/-таган; эм ба саармаг үсгийг дагах ёс нь, нэ ину -лүгээ -нүгүүд -дэгэн -тэгэн; нө ину -лүгээ -нүгүүд -дэгэн -тэгэн; нү ину -лүгээ -нүгүүд -дэгэн -тэгэн; ни ину -лүгээ -нүгүүд -дэгэн -тэгэн; Бас йа дэвсгэрийн доор




ГАЛИГ

- 18.01 na ɣa da ma la ra sa doluyan üsüg-i debisçü dabqur
- 18.02 debisker kemedeg bui. ali bui kemebesü ayin ayin ayid ayim
- 18.03 ayil ayir ayis metü bui. egün-ü dotur-a üjegülügsen inu üsüg-yin
- 18.04 bayidal-i güiçedken çidayсан ügei bolbaçu sayi surqu keüked-dür
- 18.05 üliгерлен uqayulbasu asuru dutaydaqu ügei bolju bolqu
- 18.06 bolbau kememüi kemegsen egüni mongyol ulus-un arban jiryuduyar on

ХӨРВҮҮЛЭГ

на га да ма ла ра са долоон үсгийг дэвсэж давхар дэвсгэр хэмээдэг буй. Аль буй хэмээвээс айин айиг айид айим айил айир айис мэт буй. Үүний дотор үзүүлсэн нь үсгийн байдлыг гүйцэтгэн чадсангүй боловч сая сурах хүүхдэд үлгэрлэн ухуулбаас асар дутагдахгүй болж болох болов уу хэмээмүй хэмээсэн үүнийг Монгол улсын арван зургаадугаар он



ГАЛИГ

- 19.01 čayan sar-a böged ibropa-yin nigen mingyan yisün jayun qorin
- 19.02 jiryuduγar on γurban sarayin sayin edüre mongγol ulus-un
- 19.03 sudur bičig-ün küriyeleng-ün daruγ-a jamiyang kemegdekü ber bičibei.
- 19.04 egün-iyer sayi surqu keüked-yin oyun-u ama negegdekü boltuγai.

ХӨРВҮҮЛЭГ

цагаан сар бөгөөд европын нэгэн мянга есөн зуун хорин зургаадугаар он гурван сарын сайн өдөр Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн дарга Жамьян хэмээгдэх бээр бичив. Үүнээр сая сурах хүүхдийн оюуны ам нээгдэх болтугай.

Ашигласан ном

Ринчен. Б. (2015). Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн дэвтэр. Удиртгал. Эрхлэн хэвлүүлсэн Э.Пүрэвжав, Улаанбаатар: Соёмбо принтинг. 115 тал.

Пүрэвжав. Э. (2014). Их эрдэмтэн Онходын Жамьян. Хянан тохиолдуулсан Б.Энхтүвшин, Улаанбаатар: Адмон принтинг. 138-157 тал.

Жамьян О. (2014). Монгол хэл бичгийн ухаан. Эмхэтгэн хэвлүүлсэн Э.Пүрэвжав. хянан тохиолдуулсан Д.Төмөртоогоо, Улаанбаатар: Адмон принтинг. 19-39, 121-255 тал

Төмөртоогоо. Д. (1982). Монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс. “Хэл зохиол судлал” XVII боть, V дэвтэр, Улаанбаатар, 32-81 тал.